

**БАГАНУУР ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2013 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 01

Багануур

Компанийн 2012 оны үйл ажиллагаа болон
санхүүгийн тайлангийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Багануур ХК-ийн 2012 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Компанийн гүйцэтгэх удирдлага 2012 онд зорилтот түвшингийн үндсэн үзүүлэлтийг хангаж, өвлийн оргил ачааллыг амжилттай давсан гэж дүгнэсүгэй.

Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан санал шүүмжлэл, зөвлөмжийн мөрөөр төлөвлөгөө боловсруулж 2013 онд дэвшүүлсэн зорилтоо бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /М.Отгонбаяр/-д үүрэг болгосугай.

Гурав. Тогтоолын биелэлтийг хангуулах талаар гүйцэтгэх удирдлагад дэмжлэг үзүүлж гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Ж.Төмөрбаатар/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Ж.ТӨМӨРБААТАР

М.ГАНХУЯГ

БАГАНУУР ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2013 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 02

Багануур

Компанийн 2012 оны тайлан
тэнцлийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:

Нэг. Компанийн жилийн эцсийн тайлан тэнцлийг хуулийн дагуу хугацаанд нь
гаргаж, дүн шинжилгээ хийсэн гэж үзсүгэй.

Хоёр. Багануур ХК-ийн 2012 оны жилийн эцсийн тайлангийн нийт хөрөнгийн дүнг
94 060 833, 1 мянган төгрөгөөр

Үүнээс:

Актив тал:

| | |
|----------------------------|-------------------------------|
| а/ Эргэлтийн хөрөнгийг | 37 189 720,6 мянган төгрөгөөр |
| б/ Эргэлтийн бус хөрөнгийг | 56 871 112,5 мянган төгрөгөөр |
| в/ Хөрөнгө оруулалтын дүнг | 616 897,0 мянган төгрөгөөр |

Пассив тал:

| | |
|-------------------------|-----------------------------------|
| г/ Өмчийн дүнг | 15 757 936,0 мянган төгрөгөөр |
| д/ Тайлант үеийн агшийг | - 5 802 392,4 мянган төгрөгөөр |
| е/ Эздийн өмчийн дүнг | 23 535 209,8 мянган төгрөгөөр |
| ё/ Нийт өр төлбөрийг | 70 525 623,3 мянган төгрөгөөр тус |

тус баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Ж.ТӨМӨРБААТАР

М.ГАНХУЯГ

БАГАНУУР ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2013 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 03

Багануур

Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын
тайлангийн тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн Багануур ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тайланг хэлэлцээд ТОГТООХ нь:

Нэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2012 оны үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсүгэй.

Хоёр. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Ж.Төмөрбаатар/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Ж.ТӨМӨРБААТАР

М.ГАНХУЯГ

**БАГАНУУР ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2013 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 04

Багануур

Төсөв батлах батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:

Нэг. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2013 оны зардлын төсвийг 41.2
/Дөчин нэгэн сая хоёр зуун мянга/ сая төгрөгөөр баталсугай.

Хоёр. Батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаа явуулахыг Төлөөлөн удирдах
зөвлөл /Ж.Төмөрбаатар/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Ж.ТӨМӨРБААТАР

М.ГАНХУЯГ

БАГАНУУР ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2013 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 05

Багануур

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалтыг үндэслэн
ТОГТООХ нь:

Компанийн хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг хэрэгжүүлэх Төлөөлөн удирдах
зөвлөлийн гишүүдийг 1-р хавсралтаар, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус
гишүүдийг 2-р хавсралтаар тус тус баталж 2013 оны 5-р сарын 1-ны өдрөөс эхлэн
сонгон ажиллуулсугай.

ХУРЛЫН ДАРГА


НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Ж.ТӨМӨРБААТАР

М.ГАНХУЯГ

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2013 оны 05 дүгээр тогтоолын хавсралт №1



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮД

| д/д | Нэр дэвшигчийн овог, нэр | Албан тушаал | Төлөөлөл |
|-----|--------------------------|---|------------|
| 1 | Ж.Төмөрбаатар | ТӨХ-ны орлогч дарга | Төрийн 75% |
| 2 | Д.Дэлгэрцогт | ЭХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга | Төрийн 75% |
| 3 | Ж.Батболд | БОНХЯ-ны төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч | Төрийн 75% |
| 4 | Д.Дамба | УУЯ-ны стратеги төлөвлөлтийн газрын Уул уурхайн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн | Төрийн 75% |
| 5 | С.Бэхбат | ЭЗХЯ-ны Инноваци, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга | Төрийн 75% |
| 6 | Б.Батбаатар | Firebird Mongolia holdings S.a.r.l- ийн төлөөлөл | Хувийн 25% |
| 7 | Жеймс Пассин | Firebird Mongolia holdings S.a.r.l- ийн төлөөлөл | Хувийн 25% |

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2013 оны 05 дүгээр тогтоолын хавсралт №2



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД

| д/д | Гишүүний овог, нэр | Албан тушаал |
|-----|--------------------|----------------------------------|
| 1 | Л.Шарав | Хөдөө аж ахуйн их суруулийн багш |
| 2 | Ц.Батцэрэн | Тэтгэвэрт |
| 3 | Ц.Нэргүй | Хувиараа хөдөлмөр эрхлэгч |

БАГАНУУР ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2013 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 06

Багануур

Аудитын хорооны тайлан,
дүгнэлтийн тухай

Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Багануур ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлт, 2012 онд хийсэн ажлын тайланг зөвшөөрсүгэй.

Хоёр. Хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлж, компанийн санхүүгийн чадварыг сайжруулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Аудитын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.ТӨМӨРБААТАР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

М.ГАНХУЯГ

БАГАНУУР ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2013 оны 4 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 07

Багануур

“Монгол улсыг хөгжүүлэх сан”-ийн хөрөнгө
оруулалтын хэмжээгээр компанийн
хөрөнгийг нэмэгдүүлэх тухай

“Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. 2009-2011 онд “Монгол улсыг хөгжүүлэх сан”-гаас 13660.5 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийн хэлбэрээр хүлээн авсан хөрөнгө оруулалтын үнийн дүнгээр “Багануур” ХК-ийн үндсэн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тус тус нэмэгдүүлсүгэй.

2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж байгаатай холбогдуулан компанийн гаргасан хувьцааны тоонд өөрчлөлт оруулах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэхийг Төлөөлөн удирдах зөвлөл /Ж.Төмөрбаатар/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Ж.ТӨМӨРБААТАР

М.ГАНХУЯГ